



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/78

Алтрага

**Сонгон шалгаруулах үнэлгээний хороо
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих “150 хүүхдийн дотуур байрны өрөөний засвар” 20,000,000 (хорин сая) төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Г.Батсанаа
(ЕБС-ийн нийгмийн ажилтан)
Гишүүн: Н.Мягмарсүрэн
(ЕБС-ийн багш)
Нарийн бичгийн дарга: П.Агаар
(ЕБС-ийн сургалтын менежер)

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих “150 хүүхдийн дотуур байрны өрөөний засвар”-ын ажлыг хууль журмын хүрээнд зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Г.Батсанаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010181